

**“ДЭЭД БОЛОВСРОЛЫН ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙ, САНХҮҮЖИЛТ”
I САЛБАР ХУРАЛДААНААС ГАРГАХ НЭГДСЭН ЗӨВЛӨМЖ**

Монгол Улсын Их Хуралд

1. Дээд боловсролын засаглалыг сайжруулах, их, дээд сургуулийн статус, ангиллыг тодорхой болгох, их сургуулийн бие даасан байдал, академик эрх чөлөөг баталгаажуулах, сургалт – эрдэм шинжилгээ – үйлдвэрлэл – бизнесийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, судалгааны их сургууль, гарааны компанийг санхүүжүүлэх цоо шинэ, оновчтой механизмыг бүрдүүлэх, үүний тулд боловсролын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр хуулиудыг батлан мөрдүүлэх замаар дээд боловсролын тогтвортой хөгжих нөхцлийг дэмжсэн эрх зүйн орчиныг бий болгох.
2. Төрийн өмчийн их, дээд сургуулийн үйл ажиллагааны зардлын 30-аас доошгүй хувийг улсын төсөвөөс санхүүжүүлж байх явдлыг хуульчлан хэрэгжүүлэх

Жич: Эдгээр асуудлуудыг шийдэх арга замуудыг илтгэлүүдээр тодорхойлсон.

Жишээ нь:

- Дээд боловсролын сургалтын байгууллагын хөрөнгө оруулалтын уян хатан тогтолцоо бүрдээгүй, ялангуяа төрийн өмчийн их сургуулийн хувьд өөрийн үйл ажиллагааны орлогоор өөртөө хөрөнгө оруулалт хийх эрх зүйн зохицуулалттай болгох,

Энэ зохицуулалтыг яаж бий болгох вэ,

“Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай” хуулийн 5.5. дахь заалтыг “Дээд боловсролын сургалтын байгууллагыг үндсэн чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай зориулалтын барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжөөр хангах, шинэчлэх өргөтгөхтэй холбогдох хөрөнгө оруулалтыг бүрдүүлэх үүргийг үүсгэн байгуулагч, **тухайн дээд боловсролын сургалтын байгууллага** хариуцна” гэж шинэчлэн найруулах;

Мөн хуулийн 5.6. дахь хэсэг “Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн хөрөнгийг бүрдүүлэх, шинэчлэх, өргөтгөхтэй холбогдох

хөрөнгө оруулалтыг улсын төсөв, бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ” гэж шинэчлэн найруулах

Монгол Улсын Засгийн газарт

1. Бие даасан, мэргэжлийн хамтын удирдлагатай “Дээд боловсролын хөгжлийн институт” байгуулах,
2. Удирдах зөвлөл болон сургалтын хөтөлбөрийн зөвлөлд ажил олгогч, хөрөнгө оруулагчдын төлөөллийг оруулах, оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамаарч удирдах зөвлөлд орох эрхийг олгох,
3. Санхүүжилтын эх үүсвэрийг олон болгож, сургалтын төлбөрийг тогтооход сургуулийн эрх мэдлийг нэмэгдүүлэх,
4. Шинжлэх ухааны паркийг бүтээн босгох хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох, "Шинжлэх ухааны паркийн хөрөнгө оруулалтын тухай хууль"-ийн төслийг дахин боловсруулж, УИХ-аар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж, хөрөнгө оруулалтыг шийдэх.
5. “Дээд боловсролыг 2018-2024 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-г боловсруулж, дээд боловсролын байгууллагуудын дэд бүтэц, байршил, хэв шинжийн асуудлыг шийдвэрлэх, дээд боловсролын хувийн, нийтийн, олон улсын өмчийн байгууллагуудыг тэгш хөгжих нөхцлөөр хангах ажлыг зохион байгуулах.
6. Судалгааны их сургуулийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж, суурь болон хэрэглээний судалгааны санхүүжилтийн олон талт эх үүсвэрийг бий болгох, олон улсын зээл тусламжийн тодорхой хувийг судалгааны их сургуулийг хөгжүүлэхэд зарцуулах асуудлыг журамлах, хувийн секторын дэмжлэг, хөрөнгө оруулалтыг татах хөшүүрэг бий болгох, эрдэм шинжилгээний байгууллага-хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, татварын бодлогоор дэмжлэг үзүүлэх, их сургуулийг түшиглэсэн гарааны компани байгуулах үйл ажиллагааг бүх талаар дэмжих ажлыг зохион байгуулах.

Их сургуулиудын удирдлага, багш судлаачдад

1. Мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулж, хөгжүүлэх, хамтран ажиллах,

2. Дээд боловсролын байгууллагуудын хүний нөөцийг сонгон шалгаруулах, байршуулах, чадавхижуулах, эрдэмжүүлэх, урамшуулах ажлыг оновчтой зохион байгуулах бодлого баримтлах,
3. Дээд боловсролын байгууллагуудын гадаад, дотоодын түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлэх, оюуны сүлжээ үүсгэх, давуу талаараа хорших нөхцлийг бүрдүүлэх, дээд боловсролын байгууллагууд доторхи үйлдвэр, үйлчилгээний байгууллагыг бүх талаар дэмжих бодлого баримтлах,
4. Оюутны хөгжлийн асуудлыг дээд боловсролын байгууллагын анхаарлын төвд байлгаж, тэдний сурч ажиллаж амьдрах таатай нөхцлийг бий болгох бодлого баримтлах,
5. Их дээд сургуулийн судалгаа шинжилгээний ажлаас олох орлогын хэмжээг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авах,
6. Боловсролын шинэ хэлбэрийн үйлчилгээнд хамаарагдаагүй орон зайг идэвхтэй эзэмших,